

## ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ САНГИЙН ОЛОН УЛСЫН БОЛОН ЗАРИМ ГАДААД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

### INTERNATIONAL LAW AND FOREIGN LAW REGULATION OF CRIMINAL INJURIES COMPENSATION FUND

**М.НИНЖБАДГАР**

Монгол банкны Хууль, эрх зүйн газрын мэргэжилтэн

**NINJBADGAR M.**

Legal counsel, Bank of Mongolia (Central bank of Mongolia)

**Товч агуулга:** Хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлөх харилцаа гэмт хэргийн хохирогчид санхүүгийн тусламж үзүүлэх, нийтийн аюулгүй байдлыг хамгаалах, иргэд болон шүүх, цагдаагийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах төрийн үүргээс үүдэлтэй. Хохирогчид нөхөн төлбөр олгох сан үйл ажиллагаагаа явуулж, хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнө хохирогч бүр гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэх боломжтой байгаагүй. Харин гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх сан нь гэмт хэргийн хохирогчид санхүүгийн тусламж үзүүлэх, иргэд болон шүүх, цагдаагийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах үр дүнтэй бөгөөд бодит арга юм.

**Abstract:** Victim compensation was developed because of the government's moral responsibility to provide financial relief to victims of crime, to enhance public safety, and to encourage citizen cooperation with the criminal justice system. Prior to victim compensation fund and programs, victims and survivors were often not able to access financial reparation for costs associated with their victimization or loss. Criminal injuries compensation fund is real and efficient way to provide financial relief to victims of crime and to encourage citizen cooperation with the criminal justice system.

#### Удиртгал

Эрх зүй, шударга ёс, ардчилсан нийгэм - энэ бол өнөөгийн бидний амьдарч буй нийгмийг илэрхийлэгч гол ойлголтууд билээ. Эдгээр ойлголт эцсийн дүндээ хүнийг хамгаалах, түүний хөндөгдсөн эрхийг сэргээн тогтооход чиглэгддэг, тийм ч утгыг илэрхийлдэг. Хүнийг хамгаалах, түүнд эрхийг нь эдлүүлэх асуудал олон зууны туршид яригдаж, тодорхой амжилтанд хүрсэн. Гэвч хамгаалахтай зэрэгцээд зөрчих асуудал гарч ирдэг. Хүний эрхийг зөрчсөн ямар ч үйлдэл тухайн хүний дахин давтагдашгүй, эрхэм нандин мөн чанарт нь халдаж байдаг.

Төрийн зүгээс ийм үйлдлийг таслан зогсоох, гэмт хэрэгтнийг шийтгэх, хохирогчийн хөндөгдсөн эрхийг сэргээх, хохирлоо нөхөн төлүүлэх боломжоор хангах үүрэгтэй. Энэ үүргийнхээ хүрээнд дэлхийн улс орнууд гэмт хэргийн хохирогчийг хамгаалах

тухай хууль баталж, уг хуулийнхаа дагуу гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх сан байгуулан, хөтөлбөр хэрэгжүүлж, энэхүү үйл ажиллагаанд олон тэрбумын хөрөнгө (мөнгө) зарцуулж байна.

Манай орны хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ...эрхтэй” гэж, иргэдийн эрхээ хамгаалуулах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг, тус хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус зааж, уг харилцаатай холбогдох төрийн хүлээх үүргийг тус тус тунхаглан баталгаажуулсан. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх сангийн тухай асуудал хууль тогтоогчдын түвшинд яригдсаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд 2010 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулснаар бодит ажил болсон билээ. Мөн уг харилцааг зохицуулсан журмыг засгийн газраас 2011 оны 132 дугаар тогтоолын хавсралтаар баталсан. Өнөөгийн байдлаар Хохирлын сангийн тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуульд заасан дээрх үндэслэлээр Монгол Улсын Хууль зүйн яамнаас боловсруулаад байна.

Тус хуулийн төсөл боловсруулагдаж буй энэ цаг үед дэлхийн бусад улсын эрх зүйн зохицуулалтад гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчид үзүүлэх тусламж, дэмжлэг хэрхэн тусгалаа олсныг судлах нь зайлшгүй бөгөөд судалгааны ажлын зорилго үүнд оршиж байна.

### **Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх сан**

Хүний эрхийг хамгаалах асуудал дэлхий нийтийн хэмжээнд нэн тэргүүнд тавигддаг. Гэсэн хэдий ч дэлхийн өнцөг булан бүрд хүний эрхийг зөрчих, бие махбод, сэтгэл санаанд нь хор, хохирол учруулах, бүр амь насыг нь хөнөөх асуудал гарсаар байдаг билээ. Хохирсон хүн насан туршдаа биеийн болон сэтгэлийн зовиур шаналгаатай болох, амьдрах итгэлээ алдах явдал гардаг нь нууц биш. Хүн хамтаар амьдрах, үр удмаа үлдээх тавилантай учир хохирсон хүний ард давхар хохирсон хүмүүс бий болдог. Тэд хайртай дотны хүмүүсээ алдаад зогсохгүй, амьдралын эх үүсвэрээсээ салж, сэтгэлийн зовлонд унадаг.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулж шийтгэдэг ч гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн этгээд, түүгээр тэжээн тэтгүүлэгч хүмүүс өөрсдөдөө учирсан хохирлыг нөхөн төлүүлж чадахгүй байх тохиолдол олонтоо гардаг.

Энэ асуудлыг шийдвэрлэх, хохирол нөхөн төлөлтийг нэмэгдүүлэх нэг арга зам бол гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх сан байгуулах явдал юм. Өнөөдөр бараг дэлхийн улс орон бүр гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх санг үүсгэн байгуулж, хөтөлбөр хэрэгжүүлж байна.<sup>1</sup>

Энэхүү сан гэмт хэрэгтэн учруулсан хохирлоо хохирогчид нөхөн төлөх Англи-Саксоны эрх зүйн системээс үүсэлтэй. 1950 онд Английн нийгмийн шинэчлэлийн зүтгэлтэн Margery Fry энэ санааг дэвшүүлж байсан. Шинэ Зеланд хууль тогтоомждоо 1963 оноос энэ асуудлыг тусгаж эхэлсэн бол 1979 онд АНУ-ын Техас мужийн хууль тогтоох байгууллагаас Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх актыг баталж, уг хөтөлбөрийг эхлүүлсэн. Харин АНУ холбооны хэмжээнд 1984 онд Гэмт хэргийн хохирогчийн тухай хуулийг батлан гаргасан бөгөөд уг хуулиар гэмт

<sup>1</sup> Гэмт хэргийн улмаас учирсан хохирол сургалтын гарын авлага, УБ хот, 2008 он, 122, 123 дахь тал

хэргийн хохирогчийн сан байгуулах, санг бүрдүүлэх, санхүүжүүлэх, хуваарилах, нөхөн төлбөр олгох хохирол, нөхөн төлбөр олгох эрх зүйн үндэслэл, журам, уг ажлыг зохион байгуулах зэрэг асуудлыг хуульчилсан байна. ХБНГУ Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох тухай хуулийг 1976 онд батлан гаргаж, нөхөн төлбөр олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Харин Их Британи гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн тухай хуулийг 1995 онд батлан гаргасан бөгөөд тус хуулийн дагуу хохирлыг нөхөн төлөх хөтөлбөрийг мөн хэрэгжүүлж байна.

Гэмт хэрэг үйлдсэн зарим хүн учруулсан хохирлоо барагдуулах чадваргүй, боломжгүй байдаг, харин зарим нь тийм сонирхолгүй байх, шүүхийн шийдвэр гарсан ч биелэгдэхгүй байх, дутуу биелэгдэх тохиолдол гардаг. Тиймээс энэ сангийн үндсэн зорилго нь гэмт хэргийн улмаас хууль ёсны эрх, эрх чөлөө нь зөрчигдөж хохирсон хүнд туслалцаа үзүүлэх, түүнд учирсан хохирлыг нөхөн төлөх явдал юм.<sup>2</sup>

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх сан нь:

- Улсын зардлаар;
- Хандив;
- Нөхөн төлбөр (Гэмт хэрэгтэн учруулсан хохирлын хэмжээгээр уг санд нөхөн төлбөр төлнө)-өөр санхүүждэг.

Хохирогч болон бусад хүсэлт гаргах эрх бүхий этгээд санд эсвэл цагдаагийн байгууллагад хохирол нөхөн төлүүлэх талаарх хүсэлтийг<sup>3</sup> тухайн улсын хуульд заасан хугацааны дотор гаргана. Нөхөн төлөгдөх зүйлс болон хэмжээ, хугацааг тухайн улсын хууль тогтоомжийн дагуу тодорхойлдог. Хүсэлт гаргасны дараа хууль хэрэгжүүлэх болон бусад байгууллага хүсэлтийг биелүүлэх арга хэмжээ авна. Хэрэв хохирогч болон нэхэмжлэгч нь хохирлыг нөхөн төлүүлэх сангийн шийдвэр, үйл ажиллагааг дэмжихгүй, санал нийлэхгүй байвал хуульд заасан хугацаанд давж заалдаж болно.

## **Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх сангийн эрх зүйн зохицуулалт**

### **А. Олон улсын эрх зүйн зохицуулалт**

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх сан дотоодын хууль тогтоомжоор төдийгүй, олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу тодорхойлогдон зохицуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж байна. Үндэсний төдийгүй олон улсын эрх зүйн хэм хэмжээнд илрэлээ олсон энэ сан хохирогчийн эрхийг сэргээх түүнд учирсан хохирлыг нөхөн төлөх бодит боломж, үр дүн болон хэрэгжиж байна.

Хохирогчийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг дараах олон улсын баримт бичигт заасан байдаг.

1. “Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол”<sup>4</sup> -ийн 8.1.f. “хохирогч хүүхдэд нөхөн төлбөр олгох тухай шүүхийн тогтоол болон шийдвэр гүйцэтгэлийг онцын шаардлагагүйгээр хойшлуулахаас зайлсхийнэ”;

<sup>2</sup> [http://www.oag.state.tx.us/victims/about\\_comp.shtml](http://www.oag.state.tx.us/victims/about_comp.shtml)

<sup>3</sup> <http://www.doj.state.wi.us/ocvs/compensation/compensation-your-financial-losses>

<sup>4</sup> Ерөнхий Ассамблейн 2000 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн A/RES/54/263 тогтоолоор баталж, 2000 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон. МУ 2001 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр гарын үсэг зурж, 2002 оны 10 сарын 11-ний өдөр нэгдэн орсон. Төрийн мэдээлэл тусгай дугаар 1 боть, 2004 он, 85-93 дахь тал

2. “Хүн барьцаанд авахын эсрэг олон улсын конвенц”<sup>5</sup> -ийн 3 дугаар зүйл “барьцааны хүнийг сулласны дараа шаардлагатай тохиолдолд уг улсаас гарахад нь тусламж, дэмжлэг үзүүлэх талаар зохистой гэж үзсэн бүх арга хэмжээг авна”;

3. “Үндэстэн дамнасан зохион байгуулалтай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц”<sup>6</sup> -ын 25.2 “Оролцогч улс бүр энэхүү конвенцид хамаарах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох болон хохирлыг арилгах талаар зохих журмыг батална”;

4. “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирсон хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тунхаглал”<sup>7</sup> -д “хохирогчийн өмнө төр өөрийн үүргийг биелүүлэхийн тулд тусгай зорилтын сан байгуулах, бэхжүүлэх ёстой. Хэрэв сан нь өөрийн үүргийг биелүүлэх боломжгүй бол энэ зориулалтаар нэмэлт сан байгуулах боломжийг ашиглах ёстой. Хохирол барагдуулах албан, албан бус механизм нь хялбар, хэрэгжих боломжтой байхаас гадна шударга, зохих судалгаанд үндэслэсэн, өртөг чирэгдэл багатай байна. Хохирогчийн хохирлыг барагдуулахаас гадна түүний гэр бүлийн гишүүн, халамжид буй бүх хүмүүс нөхөн төлбөр авах эрхээр хангагдах ёстой” ;<sup>8</sup>

5. НҮБ-ын Конгрессоос 2000 онд баталсан “Гэмт хэрэг ба шүүх эрх мэдэл: XXI зууныхариу” Венийн тунхаглалын 27 зүйлд “Бид 2002 оныг хохирогчдод зориулсан тусгай сан байгуулах жил болгон тодорхойлж байна”<sup>9</sup> гэжээ.

6. “Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчдод олгох нөхөн төлбөрийн тухай Европын конвенц”<sup>10</sup> -ийг гэмт хэргийн асуудлын талаарх Европын хорооны эрх мэдлийн дагуу Засгийн газрын судлаачдын хорооноос Европын зөвлөлд бэлэн болгон өргөн барьж 1983 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс Европын зөвлөлийн гишүүн улсуудад гарын үсэг зурахад нээлттэй болсон. Конвенц нь амьдрал, биеийн бүрэн бүтэн байдал, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах зорилготой.<sup>11</sup>

Энэ конвенц нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх сангийн талаарх эрх зүйн зохицуулалтын голлох эх сурвалж бөгөөд дараах зохицуулалтыг шууд агуулснаараа ач холбогдолтой.

Уг конвенцийн 16 дугаар зүйлд нөхөн төлбөр олгох гэмт хэргүүдийг дараах байдлаар зааж өгсөн:

- санаатай үйлдэгдсэн гэмт хэрэг;
- хүч хэрэглэж үйлдсэн гэмт хэрэг;
- эрүүл мэндэд хохирол учруулсан эсвэл бие мах бодид хүнд гэмтэл шууд учруулсан гэмт хэрэг.<sup>12</sup>

Конвенцид эрүүл мэнд, гэмтэл бэртэл гэх ойлголтод юу багтах талаар

<sup>5</sup> 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталж, 1983 оны 6 дугаар сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Төрийн мэдээлэл тусгай дугаар 4 боть, 2007 он, 904-910 дахь тал

<sup>6</sup> НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталж, 2003 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 2008 оны 5 дугаар сарын 25-ны өдөр гарын үсэг зурж, 2008 оны 6 дугаар сарын 26-ны өдөр соёрхон баталсан.

<sup>7</sup> НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны А/RES/40/43 тоот тогтоолоор баталсан.

<sup>8</sup> Хохирогчийн эрхийн судалгааны төв, Гэрч хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал судалгааны тайлан, УБ хот, 2010 он, 39 дэх тал

<sup>9</sup> Мөн тэнд

<sup>10</sup> European convention on the Compensation of victims of Violent Crimes

<sup>11</sup> <http://conventions.coe.int/Treaty/Commun/QueVoulezVous.asp?NT=116&CM=1&CL=ENG>

<sup>12</sup> Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчдод олгох нөхөн төлбөрийн тухай Европын конвенц /European convention on the Compensation of victims of Violent Crimes/-ийн 16 дугаар зүйл

тодорхойлж өгсөн. Эрүүл мэнд гэдэгт улс бүрийн үндэсний эрх зүйн зохицуулалтын дагуу сэтгэцийн болон биеийн эрүүл мэнд орно. Гэмтэл бэртэл нь хүнд байх ёстой бөгөөд шалтгаан, үр дагавар, баримт бүхий, гэмт хэрэгтэй шууд хамааралтай байх ёстой.

Мөн нөхөн төлбөр авах эрх бүхий этгээдийг зааж өгсөн.<sup>13</sup> Дараах этгээдүүд нөхөн төлбөр авах эрхтэй.

1. Хохирогч;

Хохирогчийн бие махбодид ноцтой гэмтэл бэртэл, эрүүл мэндэд хохирол учирсан бол хохирогчийн хохирлыг шууд нөхөн төлөх ёстой. Хохирогчоор тэжээн тэтгүүлэгчийн ашиг сонирхол нь шууд бус байна. Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтнийг баривчлах эсвэл хохирогчид туслахыг оролдож байгаад алагдсан эсвэл гэмтсэн этгээд хамаарна;

2. Хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн тэжээн тэтгүүлэгч (хүүхэд, эхнэр, нөхөр).

Сангаас олгох нөхөн төлбөр нь гэмт хэрэгтэн шүүн таслагдсан эсхээс үл хамааран хохирогчид олгогдох ёстой. Учир нь үндэсний хууль тогтоомжоор тодорхойлсон тодорхой ангилал нь (жишээлбэл: насанд хүрээгүй, сэтгэцийн өвчтэй гэх мэт) гэмт хэрэгтнийг шүүн таслах ажиллагааны субъект биш болгох, өөрсдийн үйлдэлд хариуцлага хүлээхгүй байх шалтгаан болдог. Мөн шүүн таслагдсан гэмт хэрэгтнүүд ял шийтгэлээс зугтдаг. Эдгээр нөхцөл байдлын улмаас хохирол бусад эх сурвалжаас бүрэн төлөгдөх боломжгүй тохиолдолд нөхөн төлбөрийг тухайн улсын төр нөхөн төлөхөөр заасан нь хохирогч хариуцагч олдоогүй, оргон зайлсан, насанд хүрээгүй, сэтгэцийн өвчтэй гэх мэт шалтгааны улмаас хохирлоо нөхөн төлүүлж чадахгүй байдал үүсэхээс хамгаалсан хамгаалалт болсон.

Уг конвенцын 28-р зүйлд дараах хохирлыг заавал нөхөн төлөхөөр заасан:

- Орлогын алдагдал (Жишээ нь гэмтэл бэртлээс шалтгаалан олох ёстой байсан орлогоо алдсан);

- Эмнэлгийн зардал (Эмнэлэг, эм болон шүдний эмчилгээний төлбөрийг багтаана);

- Оршуулгын зардал;

- Тэжээн тэтгүүлэгчийн хувьд (хүүхэд, эхнэр, нөхөр) тэтгэлгийн алдагдал.

Үндэсний хууль тогтоомжид заасан бусад нөхцөлийн дагуу хохирогч “өвчин шаналгаа, зовиур, амьдралын итгэл, найдвараа алдах, гэмт хэргийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсноос үүдэлтэй нэмэлт зардлууд” гэх мэт тодорхой зардлыг нөхөн төлүүлэх боломжтой.

Дээрх хохирлын нөхөн төлөх хэмжээг улсаас тогтоож, нөхөн төлдөг байна.<sup>14</sup>

Конвенцын 31-р зүйлд “Хохирогч, хэрвээ хохирогч нас барсан бол түүний тэжээн тэтгүүлэгч нөхөн төлбөр авах тухай хүсэлтийг тухайн улсын хууль тогтоомжид заасан хугацаанд багтаан, гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш боломжит хугацаанд гаргана” гэжээ.

Энэ конвенци улс орнуудын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх сан байгуулах, хууль тогтоомждоо тусгах үндэс суурь болсноороо чухал ач холбогдолтой.

<sup>13</sup> Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчдод олгох нөхөн төлбөрийн тухай Европын конвенц /European convention on the Compensation of victims of Violent Crimes/-ийн 20 дугаар зүйл

<sup>14</sup> European convention on the Compensation of victims of Violent Crimes, <http://conventions.coe.int/Treaty/Commun/QueVoulezVous.asp?NT=116&CM=1&CL=ENG>

## **Б. Зарим гадаад улсын зохицуулалт**

Энд АНУ, Канад, Япон, БНСУ гэсэн 5 улс орны гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх санг байгуулан хөтөлбөр хэрэгжүүлдэг эсэх, хэрхэн хүсэлт гаргах, нөхөн төлбөр авах эрх бүхий этгээд хэн байх, хүсэлт гаргах хугацааны тухай, процесс, нөхөн төлөгдөх хохирол, нөхөн төлбөрийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийн талаар авч үзсэн.

Эдгээр улсыг сонгож авахдаа эрх зүйн бүл, хөгжлийн түвшин, газар зүйн байрлалыг харгалзан үзсэн болно.

### **1. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх санг байгуулан хөтөлбөр хэрэгжүүлдэг эсэх:**

АНУ- Victims of Crime act буюу Гэмт хэргийн хохирогчийн тухай хуулийг 1984 онд баталсан бөгөөд энэ хуулийнхаа дагуу гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх санг байгуулсан.<sup>15</sup> АНУ бие хүний эсрэг эсвэл хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид санхүүгийн тусламж үзүүлэх, нөхөн төлбөр олгох хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Муж улс бүр өөрийн хууль тогтоомжийн дагуу өөрсдийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. АНУ-ын Хууль зүйн яам муж улсууддаа Гэмт хэргийн хохирогчийн тухай хуулийн дагуу техникийн дэмжлэг үзүүлж, санхүүжүүлдэг байна.

Канад- 1988 онд Хохирогчийн нөхөн төлбөрийн тухай хууль баталсан. Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Япон- Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох тухай хууль 1980 онд батлагдсан. Япон улс хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид санхүүгийн нөхөн төлбөр олгох хөтөлбөр хэрэгжүүлдэг.

БНСУ- Crime victim protection act<sup>16</sup> буюу Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид санхүүгийн нөхөн төлбөр олгох хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Дээр дурдсан улс бүр өөрийн оронд хохирогчийн тухай эсвэл хохирогчийн нөхөн төлбөрийн тухай хуулийг батлан гаргаж, энэ хуулийнхаа дагуу сан байгуулж хөтөлбөр хэрэгжүүлж байна.

## **2. Хүсэлт гаргах, нөхөн төлбөр авах эрх бүхий этгээд**

АНУ:

- Гэмт хэргийн хохирогч;
- Хүн амины гэмт хэргийн хохирогчоор тэжээн тэтгүүлэгч;
- Гэмт хэргийн хохирогчийн хамаатан садан;
- Гадаад улсын иргэд.

Канад:

- Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогч;
- Гадаад улсын иргэн;
- Хүн амины гэмт хэргийн хохирогчийн тэжээн тэтгүүлэгч.

Япон:

- Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогч;
- Япон улсад хууль ёсоор оршин суудаг бол нас барсан хохирогчийн тэжээн

тэтгүүлэгч;

<sup>15</sup> <http://ojp.gov/ovc/pubs/crimevictimsfundfs/intro.html>

<sup>16</sup> [http://ec.europa.eu/dgs/home-affairs/what-we-do/policies/organized-crime-and-human-trafficking/global-alliance-against-child-abuse/docs/commitments/ga\\_commitment\\_-\\_republic\\_of\\_korea\\_en.pdf](http://ec.europa.eu/dgs/home-affairs/what-we-do/policies/organized-crime-and-human-trafficking/global-alliance-against-child-abuse/docs/commitments/ga_commitment_-_republic_of_korea_en.pdf)

- Гадаад улсын иргэд гэмт хэрэг гарах үед Япон улсад хууль ёсоор оршин сууж байсан бол нөхөн төлбөр авах тухай хүсэлт гаргах эрхтэй. Харин жуулчид, зочид энэ эрхийг эдлэхгүй.

БНСУ:

- Гэмт хэргийн улмаас ноцтой гэмтсэн хохирогч;
- Нас барсан хохирогчийн тэжээн тэтгүүлэгч;
- БНСУ-д хууль ёсны зөвшөөрөлтэй нэвтэрсэн, оршин суух хязгаараа зөрчөөгүй жуулчид буюу гадаад улсын иргэд хүсэлт гаргах эрхтэй.

Дээрх дөрвөн улсын хууль тогтоомжид хүсэлт гаргах, нөхөн төлбөр авах эрх бүхий этгээдийг ижил байдлаар хуульчлан заасан байна.

### 3. Хүсэлт гаргах хугацаа:

АНУ: Хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд гэмт хэрэг гарснаас хойш нэг жилийн дотор нөхөн төлбөр авах тухай хүсэлт гаргана.

Канад: Гэмт хэрэг гарснаас хойш нэг жилийн дотор нөхөн төлбөр авах тухай хүсэлт гаргана.

Япон: Хүсэлт гаргагч гэмт хэргийн талаар мэдээлснээс хойш 2 жилийн дотор, гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс хойш 7 жилийн дотор нөхөн төлбөр авах тухай хүсэлт гаргана.

БНСУ: Хүсэлт гаргагч гэмт хэргийг мэдээлснээс хойш 1 жилийн дотор, гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс хойш 5 жилийн дотор нөхөн төлбөр авах тухай хүсэлт гаргана.

Хүсэлт гаргах хугацаа харилцан адилгүй байгаа боловч ихэнх тохиолдолд 2 жилийн хугацаатай байна.

### 4. Нөхөн төлөгдөх хохирол:

АНУ:

- Эмнэлгийн зардал;
- Сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөөний төлбөр;
- Хөгжлийн бэрхшээлтэй болсон хохирогчийн алдсан цалин хөлс;
- Хүн амины гэмт хэргийн хохирогчоор тэжээн тэтгүүлэгчийн алдагдал;
- Оршуулгын зардал.

Дээр дурдсанаас гадна АНУ-ын олон мужид дараах зардлыг нөхөн төлдөг байна.

- Хохирогчийн урьдчилан зөвшөөрснөөр түүнийг ажилд нь эргэн оруулах үйлчилгээний зардал;

- Гэмт хэрэг гарсан газрыг цэвэрлэсэн зардал;
- Нүүлгэлтийн зардал;
- Хүний эрүүл мэндийн чухал хэрэгцээт хувийн эд хөрөнгө (нүдний шил гэх мэт)-д гарсан хохирол;

- Дахиннийгэмшүүлэхэд шаардагдах зардал;
- Өмгөөлөгчийн үйлчилгээний төлбөр.

Канад:

- Эмнэлгийн зардал;
- Сэтгэл зүйн эмчилгээний зардал;
- Алдагдсан цалингийн зардал;
- Хохирогчоор тэжээн тэтгүүлэгчийн алдагдал;
- Оршуулгын зардал;

- Дахиннийгэмшүүлэхэд шаардагдах зардал;
- Хөдөлмөрийн чадвар алдсаны зардал;
- Ажилд нь дахин оруулах үйлчилгээний зардал.

Япон: Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид санхүүгийн нөхөн төлбөр олгодог. Дээрхээс дүгнэвэл нөхөн төлөгдөх зардлыг:

- Эмнэлгийн зардал;
- Сэтгэцийн эрүүл мэндийн зардал;
- Оршуулгын зардал;
- Хохирогчийн тэжээн тэтгүүлэгчийн алдсан тэтгэлэг;
- Алдсан цалин хөлс;
- Дахин нийгэмшүүлэхэд гарах зардал;
- Бусад (өмгөөлөгчийн төлбөр, гэмт хэрэг гарсан газрыг цэвэрлэсэн зардал, нүүлгэлтийн зардал г.м) гэж ангилж болохоор байна.

### 5. Нөхөн төлбөр олгох явц:

АНУ: Нэхэмжлэгч гэмт хэрэг гарсан мужийн нөхөн төлбөр олгох эрх бүхий байгууллагад хүсэлт гаргана. Нэхэмжлэгчийн гаргасан хүсэлт, мэдээллийн үндсэн дээр тухайн байгууллага нэхэмжлэгч санхүүгийн алдагдал хүлээсэн эсэх, нөхөн төлбөр авах эрхтэй эсэхийг тодорхойлно. Ихэнх мужид нэхэмжлэгч нөхөн төлбөр олгох эрх бүхий байгууллагын нөхөн төлбөрийн хэмжээг багасгасан эсвэл татгалзсан шийдвэрийг давж заалдаж болдог.

Канад: Хүсэлт гаргагч нь гэмт хэрэг гарсан газрын цагдаагийн байгууллагад өргөдөл гаргана. Өргөдлийг нөхөн төлбөр олгох эрх бүхий байгууллага руу шууд илгээнэ. Өргөдөл гаргаснаас хойш 1–5 жилийн дотор нөхөн төлбөрийн талаарх шийдвэр гарна.

Япон: Хүсэлт гаргагч өөрийн харьяаллын муж, тойргийн цагдаагийн байгууллагад хүсэлт гаргах замаар муж, тойргийнхоо нийтийн аюулгүй байдлын комисст хүсэлтээ илгээнэ. Өргөдөл гаргаснаас хойш 5 сарын дотор нөхөн төлбөрийн талаарх шийдвэр гарна.

БНСУ: Хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд цагдаагийн байгууллагад шууд хүсэлтээ гаргана.

### 6. Нөхөн төлбөрийн хэмжээ

АНУ: Мужийн хөтөлбөрөөс хохирогчид олгох тэтгэмжийн дээд хэмжээ нь дунджаар 25000 орчим ам доллар байна.

Канад: Нөхөн төлбөр олгох хэмжээ 5000–25000 доллар байна.

Япон: Амьд үлдсэн хүнд эмнэлгийн зардлын нөхөн төлбөр: 10,790, иен (2001 оны 7-р сарын 1-с хойш үйлдэгдсэн гэмт хэргийн хувьд 15,730,000 иен).

Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэлэг: 12,730,000 иен (2001 оны 7-р сарын 1-с хойш үйлдэгдсэн гэмт хэргийн хувьд 18,492,000 иен).

БНСУ: Хөгжлийн бэрхшээлтэй болсны тэтгэлгийн хэмжээ 3,000,000-аас 6,000,000 вон байна.

Олгох нөхөн төлбөрийн хэмжээ улс бүрд харилцан адилгүй байна.

### 7. Санхүүжилтийн эх үүсвэр:

АНУ: Ихэнх мужид гэмт хэрэгтэнд оногдуулсан шийтгэлээр санхүүждэг.

Канад: Татвар болон хуульд заасан бусад төлбөрөөр санхүүжүүлдэг.



Япон: Засгийн газраас санхүүжүүлдэг.

БНСУ: Засгийн газраас санхүүжүүлдэг.

Санхүүжилтийг ихэвчлэн улсаас гаргадаг боловч нэмэлт эх үүсвэрүүдийг ашиглаж байна.

Судалгаа хийх явцад зарим улс орон дараах зохицуулалтыг хууль тогтоомждоо тусгаж өгсөн нь сайшаалтай санагдлаа.

Жишээлбэл: Япон улсад гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас өнчирсэн хүүхдэд тэтгэлэг олгодог байна. Мөн гэмт хэрэгтэн тогтоогдохгүй байх, хохирогчийн хөгжлийн бэрхшээлийн зэрэг тодорхойгүй байх зэргээс шалтгаалан хөтөлбөрийн зүгээс хурдан хугацаанд шийдвэр гаргаж чадахгүй байгаа тохиолдолд хөтөлбөрт тодорхойлогдоогүй нөхцөлийн тэтгэлгийг хүсэлт гаргагчид олгодог.

АНУ-д тус улсаас гадуур үйлдэгдсэн терроризмын улмаас амь насаа алдсан, гэмтэж бэртсэн АНУ-ын иргэд, АНУ-ын дотор үйлдэгдсэн терроризмын улмаас амь насаа алдсан, гэмтэж бэртсэн оршин суугч болон оршин суугч бус этгээд Холбооны Терроризмын эсрэг яаралтай тусламжийн хөтөлбөр буюу "Antiterrorism and Emergency Assistance Program"-с нөхөн төлбөр авах эрхтэй.<sup>17</sup>

### Дүгнэлт

Хохирогчийг хамгаалах, түүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг сэргээх, түүнд учирсан хохирлыг арилгуулах эсвэл арилгах нь төрийн үүрэг билээ.

Энэ үүрэг, эрх олон улсын болон үндэсний хууль тогтоомжид тусгалаа олж, улс орнууд "Хохирогчийг хамгаалах, түүнд учирсан хохирлыг нөхөн төлөх тухай бие даасан хууль"-ийн дагуу хохирол нөхөн төлөх сан байгуулан, хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Дэлхийн ихэнх улс оронд энэ харилцаа нь бие даасан хуулиар зохицуулагддаг, хөтөлбөр болон сангийн үйл ажиллагаа нь тодорхой хугацааны турш хэрэгжиж, үр дүнгээ өгч байгаа бол манай орны хувьд шинээр үүсч буй харилцаа, зохицуулалт хэвээр байна.

Нэгтгэн дүгнэвэл, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх сан нь хохирогч болон түүний гэр бүлийн гишүүд, тэжээн тэтгүүлэгч хохирлоо нөхөн төлүүлэх бодит боломж, үр дүнтэй арга юм.

### Санал

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх сангийн үйл ажиллагаа, зохицуулалт улам боловсронгуй болон хөгжиж, үр өгөөжөө өгч байгаа боловч манай улсын хувьд шинэ харилцаа тул эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох шаардлагатай байна.

Үүний тулд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх сангийн тухай бие даасан хууль баталж, уг хуульд дээр дурдсан олон улсын болон зарим гадаад орны жишиг зохицуулалтыг харгалзан, хохирогчийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг илүү баталгаатай болгох шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Манай улс гэрч хохирогчийг хамгаалах асуудлаар олон ажил хийж байгаагийн нэг томоохон илрэл нь энэ сан, түүний зохицуулалтын асуудал. Энэ ажил бүрэн утгаараа хэрэгжсэнээр гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчид хохирлоо нөхөн төлүүлэх бодит баталгаа болно.

<sup>17</sup> <http://ojp.gov/ovc/grants/types.html#>